



## ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/125/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Чойбалсан хот  
2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул  
Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn  
Аудитын менежер: В.Цэнгэлмаа  
Утас: 70584204 Цахим  
хаяг: Tsengelmaav@audit.gov.mn  
Аудитор: Ж.Баяртуул  
Утас: 70584207 Цахим хаяг: bayartuulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

|          |                                                             |
|----------|-------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                 |
| ТШЗ      | Төсвийн шууд захирагч                                       |
| СТА      | Санхүүгийн тайлангийн аудит                                 |
| ДОА      | Дорнод аймаг                                                |



|                                                                                                                               |          |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------|
| <b>Аудитын гэрчилгээ .....</b>                                                                                                | <b>3</b> |
| Аудитын тайлан.....                                                                                                           | 5        |
| 2.1. Оршил .....                                                                                                              | 5        |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....                                                    | 5        |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....                                                         | 5        |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....                                                          | 6        |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... | 6        |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....                                                     | 6        |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....                                                                | 6        |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....                                                                                   | 7        |
| 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....                                                                    | 7        |
| 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....                                                                   | 8        |
| 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....                                             | 9        |
| 2.12. Шилэн дансны мэдээлэл .....                                                                                             | 9        |
| 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....                                                    | 9        |
| 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....                                                                                       | 9        |
| Менежментийн захидал .....                                                                                                    | 10       |
| Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....                                                                                         | 11       |
| 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....                                                                            | 112      |
| 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....                                                                          | 113      |
| 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....                                                                             | 134      |
| 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....                                                              | 145      |
| 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....                                                                           | 16       |



#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ





## 2.1. Оршил

Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Д.Хишигт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн хандиваар ирсэн хөрөнгийг баримтжуулах талаарх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 04-нөөс 2020 оны 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 2/62 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.



Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Баяндун сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хууль, журмыг дээдэлж төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргахгүй ажиллах”-д оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баяндун сумын Засаг даргын тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баяндун сумын Засаг даргын тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Баяндун сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Баяндун сумын Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудлыг төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 545,065.3 мянган төгрөгөөс тооцон 10,901.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 10235.7 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл буурсантай холбоотой болно.



## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос **82,386.7** мянган төгрөгөөр буюу **1.0** хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мян.төг/

| Үзүүлэлт                                              | Эхний<br>үлдэгдэл  | Эцсийн<br>үлдэгдэл | Өөрчлөлт        |
|-------------------------------------------------------|--------------------|--------------------|-----------------|
| Б                                                     | 1                  | 2                  | 3=2-1           |
| Мөнгөн хөрөнгө                                        | -                  | -                  | -               |
| Авлага                                                | -                  | -                  | -               |
| Урьдчилгаа                                            | -                  | -                  | -               |
| Бараа материал                                        | 184,572.3          | 203,313.05         | 18,740.6        |
| Үндсэн хөрөнгө                                        | 1,508,370.0        | 1,608,256.4        | 99,886.4        |
| Элэгдлийн зардал                                      | -110,377.1         | -134,442.4         | -24,065.3       |
| <b>Нийт хөрөнгө</b>                                   | <b>1,582,565.3</b> | <b>1,677,127.0</b> | <b>94,561.7</b> |
| Өр төлбөр                                             | 1,642.2            | 446,2              | -1,196.0        |
| Засгийн газрын оролцоо<br>/Эздийн өмч/                | 1,580,923.1        | 1,676,680.8        | 95,757.7        |
| Хуримтлагдсан үр дүн                                  | 488,627.5          | 584,385.2          | 95,757.7        |
| Өмнөх үеийн үр дүн                                    | 488,627.5          | 488,627.5          | -               |
| Тайлангийн үеийн үр дүн                               | -                  | 95,757.7           | 95,757.7        |
| Хөрөнгийн дахин үнэлгээний<br>зөрүү                   | 442,360.6          | 442,360.6          | -               |
| Төрийн өмчийн оролцоо                                 | 649,935.0          | 649,935.0          | -               |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр<br/>хөрөнгө өмчийн дүн</b> | <b>1,582,565.3</b> | <b>1,677,127.0</b> | <b>94,561.7</b> |

Бараа материал дансны үлдэгдэл өссөн нь тайлант жилд сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар малжуулах төсөлд 16,000.0 мянган төгрөгийн малыг орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант жилд аймаг, орон нутгийн хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна. Аймгийн хөрөнгө оруулалтаар 81,9 сая төгрөгийн сумын Засаг даргын тамгын газарт тоног төхөөрөмж болон хүүхдийн тоглоомын талбай, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Яргай багийн байр 18,0 сая төгрөгийн засвар хийж капиталжуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,676,680.8 мянган төгрөг болж 95,757.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилд суманд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг орлого нь элэгдлийн зардлаас их байгаагаас шалтгаалсан байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баяндун сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд 700.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 703.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна.

| Хүснэгт 2: Төвлөрүүлэх орлого |              |              | /мян.төг/  |              |
|-------------------------------|--------------|--------------|------------|--------------|
| Орлогын төрөл                 | Төлөвлөгөө   | Гүйцэтгэл    | зөрүү      | хувь         |
| Туслах үйл ажиллагаа          | 700.0        | 703.0        | 3.0        | 100.3        |
| <b>Нийт дүн</b>               | <b>700.0</b> | <b>703.0</b> | <b>3.0</b> | <b>100.3</b> |

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 311,987.2 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд төлөвлөгдсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 293,105.2 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байна.

**Нэмэлт төсөв:** Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар онцгой байдлын газраас шүлхий болон боом өвчний нөхөн төлбөр, томилолтын 62,1 сая төгрөг, Хүнс хөдөө аж ахуйн газраас оготно устгалд зориулан 8,1 сая төгрөгийг тус тус хүлээн авч зарцуулсан байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 12 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүлээ.

Аудитаар нийт 122,244.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 105,455.5 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулж, 16,686.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 102.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

1. Тайлант хугацаанд хийсэн 16,686.4 мянган төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж ....., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 13.5 дахь хэсэгт “... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

Аудитаар илэрсэн 102.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

**2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

1. Баяндун сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 10 дугаар хуралдаанаар сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны зардалд ИТХ-ын үйл ажиллагааны зардал болох 5,000.0 мянган төгрөгийн сургалт бичиг хэргийн зардлыг оруулж баталсан байна. ЗДТГ-ын хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт ИТХ-ын үйл ажиллагаа хамаарахгүй бөгөөд энэ нь *Төсвийн тухай хуулийн 6.6.6 дахь “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, 16.5.2 дахь “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байгааг сумын нэгтгэсэн тайланд тусгах саналтай байна.

2. Сумдад Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа *Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар “Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”* –д заасныг зөрчин хөрөнгө бэлтгэх, ахмадын урамшуулал, баяр наадам болон цолны найр, бусад цайллагад зарцуулж байгаа зөрчил гарч байгаа тул анхаарч ажиллах шаардлагатай байна.

**2.12. Шилэн дансны мэдээлэл**

Баяндун сумын Засаг даргын тамгын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

**2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар **тогтоосон зөвлөмжийн биелэлт** 100 хувьтай байна.

**2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**1. Тээврийн хэрэгслийн ашиглалт**

1.1. Илрүүлэлт: Сумын Засаг даргын тамгын газрын дарга нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолд заасны дагуу албан тушаалын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад хамаарахгүй байхад тайлант онд 102.6 мянган төгрөгийн шатахууныг тодорхой ажлын гүйцэтгэлгүйгээр зарцуулсан байна.

1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулагдах.

1.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг мөрдөн ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт                                                     | Эхний үлдэгдэл          | Эцсийн үлдэгдэл         |
|------------|-----------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| 1          | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                        | <b>184 572 342,85</b>   | <b>203 759 189,85</b>   |
| 33         | <b>АВЛАГА</b>                                                         | -                       | 446 174,00              |
| 33100      | Ажиллагчидтай холбогдсон авлага                                       |                         | 446 174,00              |
| 35         | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>                                                 | 184 572 342,85          | 203 313 015,85          |
| 351        | <b>Түүхий эд материал</b>                                             | 49 669 417,28           | 49 669 417,28           |
| 35110      | Тусгай зориулалттай материал                                          | 4 036 905,00            | 4 036 905,00            |
| 35130      | Эм боох материал                                                      | 45 632 512,28           | 45 632 512,28           |
| 35300      | Бэлэн бүтээгдэхүүн                                                    | 6 861 100,00            | 6 861 100,00            |
| 354        | <b>Хангамжийн материал</b>                                            | 28 446 017,57           | 31 186 690,57           |
| 35410      | Бичиг хэргийн материал                                                | 3 018 415,00            | 3 970 095,00            |
| 35420      | Аж ахуйн материал                                                     | 20 748 512,57           | 24 075 575,57           |
| 35430      | Сэлбэг хэрэгсэл                                                       | 663 200,00              | 663 200,00              |
| 35440      | Түлш, шатах тослох материал                                           | 2 763 130,00            | 1 225 060,00            |
| 35450      | Барилгын засварын материал                                            | 1 252 760,00            | 1 252 760,00            |
| 35600      | Мал амьтад                                                            | 99 595 808,00           | 115 595 808,00          |
| 2          | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b>1 397 992 938,66</b> | <b>1 473 813 972,77</b> |
| 39         | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>                                                 | 1 397 992 938,66        | 1 473 813 972,77        |
| 392        | <b>Биет хөрөнгө</b>                                                   | 1 293 388 188,72        | 1 371 271 047,85        |
| 39201      | Барилга, байгууламж, орон сууц                                        | 602 137 989,36          | 634 792 989,36          |
| 39202      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (71 903 428,91)         | (99 766 103,51)         |
| 39203      | Авто-тээврийн хэрэгсэл                                                | 109 273 600,00          | 104 084 800,00          |
| 39204      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (41 616 961,27)         | (57 721 599,88)         |
| 39205      | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 205 251 481,80          | 282 579 334,80          |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (116 897 746,95)        | (126 656 705,37)        |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил                                           | 46 260 307,50           | 48 060 307,50           |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (23 261 387,62)         | (27 174 595,10)         |
| 39209      | Зам, гүүрийн байгууламж                                               | 526 368 915,00          | 570 273 765,00          |
| 39210      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (100 357 959,87)        | (138 131 741,59)        |
| 39214      | Бусад үндсэн хөрөнгө                                                  | 241 831 807,00          | 276 804 181,00          |
| 39215      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (83 698 427,32)         | (95 873 584,36)         |
| 393        | <b>Биет бус хөрөнгө</b>                                               | 104 604 749,94          | 102 542 924,92          |
| 39301      | Програм хангамж                                                       | 2 730 000,00            | 3 662 200,00            |
| 39302      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (1 581 250,06)          | (2 175 275,08)          |
| 39303      | Бусад биет бус хөрөнгө                                                | 108 256 000,00          | 108 256 000,00          |
| 39304      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (4 800 000,00)          | (7 200 000,00)          |
| 3          | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>1 582 565 281,51</b> | <b>1 677 573 162,62</b> |
| 4          | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                                                 | <b>1 642 151,00</b>     | <b>446 174,00</b>       |
| 41         | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | 1 642 151,00            | 446 174,00              |
| 413        | <b>Өглөг</b>                                                          | 1 642 151,00            | 446 174,00              |
| 41310      | Ажилчидтай холбогдсон өглөг                                           | 1 642 151,00            | 446 174,00              |
| 5          | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>1 580 923 130,51</b> | <b>1 677 126 988,62</b> |
| 51         | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 1 580 923 130,51        | 1 677 126 988,62        |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан |                         |                         |
|            |                                                                       | 649 935 015,24          | 649 935 015,24          |
| 51101      | Өмч: - төрийн                                                         | 649 935 015,24          | 649 935 015,24          |
| 512        | <b>Хуримтлагдсан үр дүн</b>                                           | 488 627 548,08          | 584 831 406,19          |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн                                                    | 488 627 548,08          | 488 627 548,08          |
| 51220      | Тайлант үеийн үр дүн                                                  | -                       | 96 203 858,11           |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 442 360 567,19          | 442 360 567,19          |
| 6          | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b>1 582 565 281,51</b> | <b>1 677 573 162,62</b> |



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт                                                                                         | Өмнөх оны гүйцэтгэл    | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--------------------------------------------------------------------------------------------------|------------------------|-----------------------|
| 1          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                                                           | <b>574 234 575,00</b>  | <b>660 048 204,00</b> |
| 12         | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                                                                       | <b>142 682 546,00</b>  | <b>195 508 147,00</b> |
| 120        | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                                                               | 142 682 546,00         | 195 508 147,00        |
| 120004     | Төсөв байгууллагын өөрийн орлого                                                                 | 142 682 546,00         | 703 900,00            |
| 1200042    | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                                                        | 1 000 000,00           | 703 900,00            |
| 1200045    | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого                                                                | 141 682 546,00         | -                     |
| 120017     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн                                                         | -                      | 178 694 247,00        |
| 120018     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бариаг                                                         | -                      | 16 110 000,00         |
| 13         | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                                             | <b>431 552 029,00</b>  | <b>464 540 057,00</b> |
| 1311       | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                                               | 39 403 355,00          | 81 231 957,00         |
| 131101     | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан                                              | 22 500 000,00          | -                     |
| 131103     | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй                                                   | 9 100 000,00           | 9 607 680,00          |
| 131104     | нооц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан                                             | -                      | -                     |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан                                                 | -                      | -                     |
| 131104     | төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан                                                | 3 385 655,00           | 71 157 577,00         |
| 131105     | төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны                                                      | 4 417 700,00           | 466 700,00            |
| 1320       | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>                                                            | 392 148 674,00         | 383 308 100,00        |
| 132001     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн                                                  | 337 167 300,00         | 383 308 100,00        |
| 132007     | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих                                                          | 54 981 374,00          | -                     |
| 2          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                                                               | <b>545 056 326,53</b>  | <b>563 844 345,89</b> |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                                             | <b>519 296 326,53</b>  | <b>534 720 845,89</b> |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                                           | 503 158 365,25         | 499 042 510,73        |
| 2101       | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                                                         | 201 543 712,00         | 208 680 572,06        |
| 210101     | Үндсэн цалин                                                                                     | 170 039 447,00         | 174 087 824,75        |
| 210104     | Урамшуулал                                                                                       | -                      | 6 383 420,00          |
| 210105     | Гэрээт ажлын хөлс                                                                                | 31 504 265,00          | 28 209 327,31         |
| 2102       | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                                            | 24 583 933,72          | 26 069 791,36         |
| 210201     | Тэтгэврийн даатгал                                                                               | 16 499 577,72          | 18 020 663,36         |
